

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит

Аудитын код: САГ-2021/14/СТА-ТЭЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2021 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын дөрөвдүгээр газрын захирал,
тэргүүлэх аудитор: Я.Самбууням
Утас: 260949
Цахим хаяг: sambuunyamyа@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261628
Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 260512
Цахим хаяг: nyamtsetsegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал.....	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт.....	9
3.5.1 Мөнгөн хөрөнгө.....	9
3.5.2 Авлага.....	9
3.5.3 Бараа материал.....	10
3.5.4 Үндсэн хөрөнгө.....	10
3.5.5 Өр төлбөр.....	11
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал.....	13
3.9 Шилэн дансны мэдээлэл.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
5. Менежментийн захидал.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16
6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН
ХОРООНЫ ДАРГА Б.БАТДАВАА
ТАНАА

2021.04.26 № 1324
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

A square red stamp containing a handwritten signature in black ink. The signature is written in a cursive style and appears to read 'Д.ЗАНДАНБАТ'. The stamp is slightly faded and has a thin red border.

Д.ЗАНДАНБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	443,317.9	699,634.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	18,862.7	9,762.7
33	АВЛАГА	151,601.2	402,868.2
35	БАРАА МАТЕРИАЛ	272,854.1	287,003.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,308,121.4	4,825,291.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,308,121.4	4,825,291.0
39200	Биет хөрөнгө	1,191,225.9	4,234,091.4
39300	Биет бус хөрөнгө	116,895.5	591,199.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,751,439.3	5,524,925.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,035.0	16,593.7
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,035.0	16,593.7
41300	Өглөг	5,035.0	16,593.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,746,404.2	5,508,331.4
51	Засгийн газрын хувь оролцоо	1,746,404.2	5,508,331.4
51200	Хуримтлагдсан үр дүн	1,740,560.0	5,502,487.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,844.2	5,844.2
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,751,439.3	5,524,925.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	16,370,577.8	18,785,018.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	245,657.8	3,052,419.6
120	Нийтлэг татварын бус орлого	245,657.8	3,052,419.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,124,919.9	15,732,598.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	16,376,829.7	15,018,707.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,376,829.7	15,018,707.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,936,248.7	14,566,824.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,454,135.5	5,494,344.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	534,140.4	687,994.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	900.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	676,111.0	552,971.6
2105	Нормативт зардал	5,446.0	334.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	66,368.5	27,717.1
2107	Томилолт, зочны зардал	314,494.5	250,217.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,878,426.4	6,864,222.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,006,226.3	689,022.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	440,581.0	451,882.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(6,251.9)	3,766,311.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	46.6	3,953.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(6,298.6)	3,762,357.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,752,702.8	-	1,752,702.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,752,702.8	-	1,752,702.8
Тайлант үеийн үр дүн	(6,298.6)	-	(6,298.6)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,746,404.2	-	1,746,404.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(430.5)	-	(430.5)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,745,973.8	-	1,745,973.8
Тайлант үеийн үр дүн	3,762,357.6	-	3,762,357.6
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,508,331.4	-	5,508,331.4

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 оны 12-р сарын 31	2020 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	16,242,328.6	15,891,569.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,050.4	10,759.1
120	Нийтлэг татварын бус орлого	27,050.4	10,759.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	16,215,278.2	15,880,810.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,076,800.9	14,918,800.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,076,800.9	14,918,800.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,487,464.6	14,067,131.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,443,858.3	5,522,440.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	539,275.8	682,587.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	900.0	-
2104	Хангамж, бараа материалын зардал	634,625.6	517,516.6
2105	Нормативт зардал	4,846.0	334.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	89,025.0	30,881.1
2107	Томилолт, зочны зардал	314,605.5	270,632.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,961,215.6	6,828,938.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	499,112.7	213,800.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	589,336.3	851,668.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	165,527.7	972,769.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	147,557.9	981,869.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	147,557.9	981,869.0
2200	Дотоод эх үүсвэрээр	147,557.9	981,869.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(147,557.9)	(981,869.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	17,969.9	(9,100.0)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	892.8	18,862.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,862.7	9,762.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,629,996,700.00	13,621,336,335.81	1,008,660,364.19	93.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,029,996,700.00	13,029,223,465.81	1,000,773,234.19	92.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,842,633,700.00	12,867,698,710.81	974,934,989.19	92.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,070,314,900.00	4,973,626,945.94	96,687,954.06	98.09
210101	Үндсэн цалин	3,354,193,500.00	3,235,379,054.62	118,814,445.38	96.46
210102	Нэмэгдэл	1,074,740,100.00	1,074,664,148.20	75,951.80	99.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	372,696,000.00	356,847,543.66	15,848,456.34	95.75
210104	Урамшуулал	268,685,300.00	306,736,199.46	(38,050,899.46)	114.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	684,344,500.00	637,528,727.30	46,815,772.70	93.16
210201	Тэтгэврийн даатгал	481,531,700.00	463,907,267.43	17,624,432.57	96.34
210202	Тэтгэмжийн даатгал	50,703,300.00	42,981,748.82	7,721,551.18	84.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	40,562,700.00	33,685,875.53	6,876,824.47	83.05
210204	Ажилгүйдлийн даатгал	10,140,500.00	9,700,746.64	439,753.36	95.66
210205	Эрүүл мэндийн даатгал	101,406,300.00	87,253,088.88	14,153,211.12	86.04
2104	Хангамж, бараа материалын зардал	137,346,300.00	120,536,829.57	16,809,470.43	87.76
210401	Бичиг хэрэг	28,536,500.00	26,213,210.00	2,323,290.00	91.86
210402	Тээвэр, шатахуун	39,319,000.00	36,951,926.00	2,367,074.00	93.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	37,765,500.00	37,673,646.57	91,853.43	99.76
210404	Ном, хэвлэл	12,250,100.00	1,535,340.00	10,714,760.00	12.53
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,475,200.00	18,162,707.00	1,312,493.00	93.26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	217,042,000.00	208,289,235.00	8,752,765.00	95.97
210601	Багаж, техник, хэрэгсэл	210,700,000.00	202,147,235.00	8,552,765.00	95.94
210604	Урсгал засвар	6,342,000.00	6,142,000.00	200,000.00	96.85
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	207,000.00	-	100.00
210702	Дотоод албан томилолт	207,000.00	207,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,671,537,300.00	6,906,648,431.00	764,888,869.00	90.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,415,619,100.00	6,652,142,752.00	763,476,348.00	89.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	118,800.00	118,800.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	30,044,700.00	29,815,546.00	229,154.00	99.24
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,625,900.00	2,702,752.00	923,148.00	74.54
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	497,500.00	288,700.00	208,800.00	58.03
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	36,691,900.00	36,691,900.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	184,939,400.00	184,887,981.00	51,419.00	99.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,841,700.00	20,861,542.00	40,980,158.00	33.73

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,530,400.00	13,112,362.00	2,418,038.00	84.43
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	46,311,300.00	7,749,180.00	38,562,120.00	16.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	187,363,000.00	161,524,755.00	25,838,245.00	86.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	28,382,000.00	28,261,000.00	121,000.00	99.57
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	28,382,000.00	28,261,000.00	121,000.00	99.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	158,981,000.00	133,263,755.00	25,717,245.00	83.82
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	138,011,800.00	118,488,955.00	19,522,845.00	85.85
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,969,200.00	14,774,800.00	6,194,400.00	70.46
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	600,000,000.00	592,112,870.00	7,887,130.00	98.69
222001	Тоног төхөөрөмж	600,000,000.00	592,112,870.00	7,887,130.00	98.69
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	14,629,996,700.00	13,790,866,527.81	839,130,172.19	94.26
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,629,996,700.00	13,786,462,580.81	843,534,119.19	94.23
310001	Улсын төсвөөс санхүүжих	14,629,996,700.00	13,786,462,580.81	843,534,119.19	94.23
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	4,403,947.00	(4,403,947.00)	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,403,947.00	(4,403,947.00)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/ ТЕЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,140,968,848.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,140,968,848.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,855,633,551.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,813,531.27
210101	Үндсэн цалин	281,148,230.27
210102	Нэмэгдэл	1,505,168.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,397,973.00
210104	Урамшуулал	23,677,372.00
210105	Гэрээт ажлын хөлс	232,084,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,058,994.65
210201	Тэтгэврийн даатгал	43,697,849.65
210202	Тэтгэмжийн даатгал	337,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	169,279.00
210204	Ажилгүйдлийн даатгал	173,706.00
210205	Эрүүл мэндийн даатгал	680,572.00
2104	Хангамж, бараа материалын зардал	396,979,818.00
210401	Бичиг хэрэг	26,568,125.00
210402	Тээвэр, шатахуун	234,239,931.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,301,062.00
210404	Ном, хэвлэл	106,586,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,284,500.00
2105	Нормативт зардал	334,700.00

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	162,500.00
210502	Хоол, хүнс	172,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	157,072,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	126,912,490.00
210602	Тавилга	14,200,000.00
210604	Урсгал засвар	15,960,000.00
2107	Томилолт, зочны зардал	270,425,000.00
210702	Дотоод албан томилолт	270,425,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,257,955,183.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,245,177,983.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	176,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,450,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	8,151,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	178,993,834.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,591,619.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	133,402,215.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	285,335,296.81
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,999,181.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,999,181.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	272,336,115.81
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	272,336,115.81
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,140,968,848.43
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,140,968,848.43
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,568,078,685.43
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	289,300,107.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,280,389,206.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,200,850.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд дотоод хяналт, цалин болон бусад зардалтай холбоотой асуудлаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Ж.Нямцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 01/269 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үндэсний статистикийн хорооны эрхэм зорилгыг “Улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр эдийн засаг, нийгэм, хүн ам зүйн талаарх шинжлэх ухааны арга зүйгээр тооцсон, статистикийн үнэн бодит мэдээлэл, судалгаагаар төр, засаг, иргэн байгууллагад адил тэгш үйлчлэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Үндэсний статистикийн хорооны Дотоод аудит, мониторингийн хэлтэс 2020 онд өөрийн харьяаны нийт 20 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 284 зөвлөмж өгсөн байна. Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, акт, албан шаардлагын биелэлтийг аймаг, нийслэлийн статистикийн газар, хэлтсүүдээс авч нэгтгэн 2020 оны 6

дугаар сарын 30-ны өдрийн 02/496 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай гэж үнэлсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардал 15,025.7 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 300.5 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 18.9 сая, эцсийн үлдэгдэл 9.8 сая төгрөг болж, 9.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/	
			Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банкинд байгаа бэлэн мөнгө	18.9	9.8	-9.1	100.0
Дүн	18.9	9.8	-9.1	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 9.8 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах данс дахь ахмадын сангийн үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар нийт 13.7 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн. /Нийслэлийн статистикийн хэлтэс 10.6 сая, Дорноговь аймгийн статистикийн хэлтэс 2.6 сая, Төв аймгийн статистикийн хэлтэс 0.5 сая/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 151.6 сая, эцсийн үлдэгдэл 402.9 сая төгрөг болж,

251.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2.0	0.2	-1.8
Татаас, санхүүжилтийн авлага	149.1	398.1	249
Бусад авлага	0.5	4.6	4.1
Дүн	151.6	402.9	251.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдлийн 98.8 хувийг татаас санхүүжилтийн авлага, 1.1 хувийг бусад авлага эзэлж байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 272.9 сая, эцсийн үлдэгдэл 287.0 сая төгрөг болж, 14.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	34.2	12.9	-21.3
Бэлэн бүтээгдэхүүн	5.3	-	-5.3
Бичиг хэргийн материал	68.0	97.8	29.8
Аж ахуйн материал	102.3	117.5	15.2
Сэлбэг хэрэгсэл	6.6	8.8	2.2
Түлш, шатах тослох материал	18.2	10.3	-8.1
Хүнсний материал	0.1	0.4	0.3
Бусад хангамжийн материал	38.2	39.3	1.1
Дүн	272.9	287.0	14.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдлийн 97.8 сая төгрөг буюу 34.1 хувийг бичиг хэргийн материал, 117.5 сая төгрөг буюу 40.9 хувийг аж ахуйн материал эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийслэлийн статистикийн газар 5.1 сая төгрөгийн бараа материалыг буруу ангилан бүртгэсэн,
- Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж 11.0 сая төгрөгийн сэлбэг хэрэгслийг шууд худалдан авалт хийсэн,
- Шатахууны нормыг баримталж, жолоочийн тооцооны хуудсанд хяналт тавьж ажиллаагүйгээс нийтдээ 3.2 сая төгрөгийн шатахуун илүү олгосон /Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс 2.5 сая, Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтэс 0.5 сая төгрөг, Орхон, Дархан-Уул аймгийн статистикийн хэлтсүүд тус бүр 0.1 сая/.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 5,290.2 сая, эцсийн үлдэгдэл 9,000.2 сая төгрөг болж, 3,710.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	10.8	10.8	-
Авто-тээврийн хэрэгсэл	507.9	828.0	320.1
Машин тоног төхөөрөмж(компьютер)	4,072.5	6,551.5	2479.0

Тавилга аж ахуйн эд хогшил	576.7	649.0	72.3
Бусад үндсэн хөрөнгө	4.5	4.5	-
Ном	0.1	0.1	-
Програм хангамж	116.9	955.5	838.6
Биет бус хөрөнгө	0.8	0.8	-
Дүн	5,290.2	9,000.2	3,710.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 3,710.0 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 592.1 сая төгрөг, урсгал зардлаас 389.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн, мөн Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Ухаалаг засаг” төслийн санхүүжилтээр 2,801.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамжийг хүлээн авсантай холбоотой байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 523 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, үлдэх өртөггүй 94 нэр төрлийн 611.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассан байна.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5.0 сая, эцсийн үлдэгдэл 16.6 сая төгрөг болж, 11.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	1.1	1.1	6.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	3.0	3.0	18.1
Байгууллагад төлөх өглөг	2.8	12.5	9.7	75.3
Хувь хүнд төлөх	2.2	-	-2.2	-
Нийт дүн	5.0	16.6	11.6	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Үндэсний статистикийн хорооны байгууллагад төлөх гэрээний төлбөрийн үлдэгдэл 12.5 сая төгрөг байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,746.4 сая, эцсийн үлдэгдэл 5,508.3 сая төгрөг болж, 3,761.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,746.4	5,508.3	3,761.9	100.0
Хуримтлагдсан үр дүн	1,740.6	5,502.5	3,761.9	99.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5.8	5.8	-	0.1
Дүн	1,746.4	5,508.3	3,761.9	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,761.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Үндэсний статистикийн хороо нь 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 21,463.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 254 дүгээр тогтоолоор Үндэсний статистикийн хорооны 2020 оны төсвийн хязгаарыг 14,896.3 сая төгрөгөөр баталсан ба төсвийн ерөнхийлөн захирагч 21,463.8 сая төгрөгийн төсвийн төсөл боловсруулж хүргүүлснийг 6,833.8 сая төгрөгөөр бууруулж 14,630.0 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн зарлагыг хэт өндрөөр, бодит бус, үндэслэлгүй боловсруулсан, төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцээгүй тул бууруулсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 24 хөтөлбөрийн төсвийг 14,630.0 сая төгрөгөөр баталсан боловч 14,020.2 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 13,621.3 сая төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 96.7 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 46.8 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 764.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Үндэсний статистикийн хороонд 600.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын зардал батлагдсанаас гүйцэтгэлээр 592.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтын батлагдсан төсвөөс 219.6 сая төгрөгийн автотээврийн хэрэгсэл, 73.3 сая төгрөгийн тавилга эд хогшил, 299.2 сая төгрөгийн компьютер, тоног төхөөрөмж авч, харьяа төсвийн шууд захирагчдад хуваарилжээ.

Санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл 403.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламж, гадаад төсөл хөтөлбөрөөс 1,568.1 сая, аймаг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын нөөц хөрөнгөнөөс 289.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 3.2 сая нийт 1,860.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Ээлжит тооллогыг 2010 оноос эхлэн 10 жил тутамд нэг удаа улсын хэмжээнд явуулна.”, 8.2-т “Тооллогын товыг ээлжит тооллого явуулах хугацаанаас хоёроос доошгүй жилийн өмнө Улсын Их Хурал зарлана” гэж заасны дагуу тооллогыг 6 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөж, тоолох ажлыг орон даяар нэгэн зэрэг 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн орон нутгийн 8.00 цагаар эхлүүлж, 1 дүгээр сарын 15-ны 24 цаг хүртэл 7 хоногт багтаан явуулсан байна.

Монгол Улсын хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогоор Монгол Улсын харьяат хүн ам 3,296,866 болж, 1918 оноос 5 дахин, 2010 оноос хойш жилд дунджаар 2.2 хувийн өсөлттэй явж ирсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Үндэсний Статистикийн хороо Монгол Улсын статистикийн салбарын 2020 оны зорилгыг “Монгол Улсын Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны 4 дэх удаагийн үндэсний хөтөлбөрийг боловсруулах, статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандарт нэвтрүүлэх” гэж тодорхойлсон байна.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Статистикийн ерөнхий үйл ажиллагааны стандартыг нэвтрүүлж, албан ёсны статистикийн мэдээлэл боловсруулалтыг боловсронгуй болгох;
- Статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох, статистикийн мэдээллийг баг, хороо, сумын түвшинд задлан нийтийн хүртээл болгох;
- Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллого болон бусад тооллого, судалгааны үр дүнг боловсруулж нийтийн хүртээл болгох;
- Тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, арга зүйг боловсронгуй болгож, мета мэдээллийн сангийн баяжилтыг сайжруулах;
- Хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бататгах, статистикийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсад статистикийн чиглэлээр гарч байгаа өөрчлөлт шинэчлэлт, сайн туршлагаас суралцаж нэвтрүүлэх;

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхээр 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилтын хүрээнд нийт 238 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.

3.9 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Үндэсний статистикийн хороо нь тайлант онд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн байршуулж ажилласан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад өгсөн 0.7 сая төгрөгийн төлбөрийн 2 актыг барагдуулж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 65.1 сая төгрөгийн 4 албан шаардлага, 122.7 сая төгрөгийн 13 зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлжээ.

3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 23 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 19 байгууллагын санхүүгийн тайланд Зөрчилгүй дүгнэлт өгч, 3 байгууллагад итгэл үзүүлж, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Аудитаар нийт 405.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 253.3 сая төгрөгийн алдааг залруулж, 3.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 40.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 108.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 336.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 253.3 сая төгрөгийн алдааг залруулж, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх, харьяа байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар 82.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний статистикийн хорооноос харьяа төсвийн шууд захирагчдад хуваарилсан 248.0 сая төгрөгийн хөрөнгийг хоорондын тооцоо үүсгэж, устгах бичилт хийгээгүй, хуваарилах зорилгоор худалдан авсан үндсэн хөрөнгөд 5.3 сая төгрөгийн элэгдэл тооцсон нийт 253.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

4.2 Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 69.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 40.8 сая төгрөгийн албан шаардлага, 25.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна.

5. Менежментийн захидал

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн оруулав. Үүнд:

5.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

5.1.1 Илрүүлэлт:

Гэрээт ажилтнуудад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс илүү нийт 74.1 сая төгрөгийн цалин хөлс, 8.8 сая төгрөгийн хоолны мөнгө нэмж олгосон байна. Энэ нь Хүн

ам, орон сууцны тооллогын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д “ажилгүй болон тэтгэвэрт байгаа хүнийг статистикийн асуудал эрхэлсэн төв байгууллагад тооллогын ажилтнаар ажиллуулсан хугацаанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож олгох цалин хөлс олгоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.1.2 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажилтнуудын цалин хөлсийг хууль журамд нийцүүлэн олгох.

5.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

5.1.1 Илрүүлэлт:

Үндэсний статистикийн хорооны харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 69.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 40.8 сая төгрөгийн албан шаардлага, 25.2 сая төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.4-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах”, 14.2.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах”, 14.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Өгсөн зөвлөмж:

Харьяа төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Аудитад хамрагдалт			Залруулагдаагүй алдаа, зөрчлийн ангилал						Алдаа, зөрчлийн дүн	
		Зөрчилгүй дүгнэлт	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн /сая төг/
					Тоо	Дүн /сая төг/	Тоо	Дүн /сая төг/	Тоо	Дүн /сая төг/		
A	1	3	4	5	7	8	9	10	11	12	13	14
1	Үндэсний статистикийн хороо	1			1	-					1	-
1	Архангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1			2	-		-		-	2	-
2	Баян-Өлгий аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-		-	-	-
3	Баянхонгор аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-		-	-	-
4	Булган аймаг дахь Статистикийн хэлтэс	1			3	-	1	0.4		-	4	0.4
5	Говь-Алтай аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1	-	3	2.1	5	14.7	9	16.8
6	Говьсүмбэр аймаг дахь Статистикийн хэлтэс	1			3	-	1	0.5	1	0.4	5	0.9
7	Дархан-Уул аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1	0.1		-		-	1	0.1
8	Дорноговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1	2.6		-		-	1	2.6
9	Дорнод аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-	2	1.1	2	1.1
10	Дундговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-	1	-	1	-
11	Завхан аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-		-	-	-
12	Орхон аймаг дахь Статистикийн хэлтэс	1			2	1.4		-		-	2	1.4
13	Өвөрхангай аймаг дахь Статистикийн хэлтэс	1			1	0.5		-		-	1	0.5
14	Өмнөговь аймаг дахь Статистикийн хэлтэс	1			2	-	1	0.1	1	-	4	0.1
15	Сүхбаатар аймаг дахь Статистикийн хэлтэс			1	3	2.3		-	1	3.3	4	5.6
16	Сэлэнгэ аймаг дахь Статистикийн хэлтэс			1		-		-		-	-	-
17	Төв аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-		-	-	-
18	Увс аймаг дахь Статистикийн хэлтэс	1				-		-		-	-	-
19	Ховд аймаг дахь Статистикийн хэлтэс	1			2	0.2		-		-	2	0.2
20	Хөвсгөл аймаг дахь Статистикийн хэлтэс			1		-		-		-	-	-
21	Хэнтий аймаг дахь Статистикийн хэлтэс	1			2	7.3	1	0.5		-	3	7.8
22	Нийслэлийн Статистикийн газар	1			4	10.8		-	2	21.3	6	32.1
23	Үндэсний статистикийн хороо (аппарат)		1		1	82.9					1	82.9
	НИЙТ ДҮН	19	1	3	29	108.1	7	3.7	13	40.8	49	152.6

6. Төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
Төсвийн шууд захирагч					
Нийслэлийн статистикийн хэлтэс					
1	Байгууллагын бүх ажилчдад үндсэн цалингийн 40 хувиас илүү бодож нийт 16.3 сая төгрөгийн урамшууллыг хавтгайруулан олгож төсвийг үрэлгэн зарцуулсан	16.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Ц.Заяахүү Ц.Мягмарсүрэн
2	Анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 5.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн	5.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Ц.Заяахүү Ц.Мягмарсүрэн
Булган аймгийн статистикийн хэлтэс					
1	Үр дүнгийн урамшуулал давхар авсан	0.4	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	М.Мөнхбат Ж.Чинчулуун
Говь-Алтай аймгийн статистикийн хэлтэс					
1	Тушаал шийдвэргүйгээр 0.2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон	0.2	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
2	Шатахууны тооцоогоор 0.1 сая төгрөгийн шатахууны үлдэгдлийг тооцоо бодож бүртгэлд тусгаагүй	0.1	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
3	Тайлант онд албан томилолтын тооцоогоор 0.8 сая төгрөг илүү, 1.0 сая төгрөг дутуу олгосон	1.8	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
4	Автомашин сэлбэг засварын материалын төсөвт өртөг босго үнээс давсан байхад худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй	11.0	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
5	Жолоочийн тооцоог шалгахад 2.4 сая төгрөгийн спидометрийн заалтыг давхардуулан зардал гаргасан	2.4	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
6	Цалингийн сангаас 0.7 сая төгрөгийн шагнал олгосон, улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх зардлаас 0.2 сая төгрөгийн сэлбэг авсан	0.9	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
7	Шилэн дансны цахим хуудсанд 5 мэдээлэл мэдээлээгүй	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
8	Ажиллагсдаас 0.5 сая төгрөгийн ҮЭ татвар суутгасан боловч аймгийн ЗДТГ-т хамтын гэрээгээ бүртгүүлээгүй	0.5	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Тунгалаг А.Банзрагч
Говьсүмбэр аймгийн статистикийн хэлтэс					

Үндэсний статистикийн хорооны даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1	2020 оны 1 дүгээр сарын жолоочийн тооцооны хуудсанд хяналт тавьж ажиллаагүй, шатахууны нормыг баримталж ажиллаагүй, 0.5 сая төгрөгийн шатахуун илүү зарцуулсан	0.5	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Л.Мөнгөнцэцэг Ч.Болормаа
2	Шилэн дансанд хөрөнгө зарцуулах 2, үр дүнгийн урамшууллын 3 тушаал оруулаагүй	0.4	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Л.Мөнгөнцэцэг Ч.Болормаа
Дорнод аймгийн статистикийн хэлтэс					
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 1.1 сая төгрөгийн ХХОАТ суутган авсан байна.	1.1	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Энхбаатар О.Гэрэлтуяа
2	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 45.6 сая төгрөгийн орлого, 35.9 зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Д.Энхбаатар О.Гэрэлтуяа
Дундговь аймгийн статистикийн хэлтэс					
1	Шатахууны тооцоог батлагдсан маягтын дагуу бодож баталгаажуулаагүй	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Энхтуяа Г.Сайхантуяа
Өмнөговь аймгийн статистикийн хэлтэс					
1	Ээлжийн амралтын амарсан хоногийг тулган баталгаажуулахад 1 хүнд 5 хоногийн цалинг давхардуулан олгож суутган тооцоо хийсэн байгаа боловч 0.1 сая төгрөгийг дутуу тооцсон байна	0.1	Акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	С.Бямбабаатар М.Оюун-Эрдэнэ
2	Тайлант оны 4-12 дугаар сард зарцуулсан шатахууны зардлыг тухай бүрд нь мэдээлээгүй хугацаа хоцроож мэдээлсэн	-	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	С.Бямбабаатар М.Оюун-Эрдэнэ
Төв аймгийн статистикийн хэлтэс					
1	Хэлтсийн даргын 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Б/02 тушаалаар 2 хүнд нягтлан бодогчийн ажлыг хавсарган гүйцэтгүүлж тус бүр 20 хувийн нэмэгдэл олгож 3.3 сая төгрөгийн зардал гаргасан	3.3	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Ж.Отгончулуун Д.Нансалмаа Ш.Ариунаа
Хэнтий аймгийн статистикийн хэлтэс					
1	Нягтлан бодогчид 0.5 сая төгрөгийн урамшуулал илүү олгож төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан	0.5	Акт тогтоох	Даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нягтлан бодогч	Г.Сэдэдмаа А.Мөнх-Уянга
Дүн		44.5			